

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН АЖИЛТНУУДЫГ  
ЧАДАВХИЖУУЛАХ 2024 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024.12.02

№	Хэрэгжүүлэх ажлууд	Төсөв /сая.төг/	Биелэлт	Гүйц. хувь
1	Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй 1 журмыг шинэчлэх, 3 журам шинээр боловсруулан батлуулах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ажлыг зохион байгуулах.	-	<p>-Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчилж, "Цалин хөлсний журам", "Албан томилолтын журам", "Зайнаас ажиллах үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг шинээр боловсруулан нийт албан хаагчдаас санал авч хэлэлцүүлэн тус газрын даргын 2024.02.23-ны өдрийн А/05 дугаар тушаалаар батлуулсан. Дээрх журмуудыг дотооддоо өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>-Зайнаас ажиллах үйл ажиллагааг зохицуулах журамд заасны дагуу 2 албан хаагчийг зайнаас ажиллуулж, ажлын тайланг нэгжийн дарга нар хүлээн авч, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцон цалин хөлсийг бүтэн тооцож олгосон.</p> <p>-Албан томилолтын журамд заасны дагуу албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг ЗУХ-ээс боловсруулан батлуулж, соёлын салбарын 12 албан хаагчдад УБ хот болон сумдад ажиллахад тухай бүрт нь өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.</p>	100%
2	Шинээр болон шинэчлэн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, дүрэм журмын талаар газрын шуурхай хурлын эрх зүйн мэдээллийн цагаар тогтмол мэдээлэл хийж байх.	-	Төрийн мэдээлэл эмхтгэлээр хэвлэгдсэн гарсан соёлын салбарын чиг үүрэгтэй холбоотой шинээр батлагдсан 1 хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 12, нэмэлт оруулсан 2 хууль, 2 конвенц, бодлогын 3 баримт бичгийн талаар нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж мэдээлэл өгсөн.	100%
3	Албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.	-	"Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн танилцуулга, төслийг соёлын нийт байгууллагуудад хүргүүлж, нийт албан хаагчдад танилцуулан гарсан 10 санал /хасах 1, нэмэлт өөрчлөлт оруулах 9/-ыг нэгтгэн дотооддоо хэлэлцүүлэн ТА3-ийн Дархан-Уул аймаг дахь СЗ-д хугацаанд нь хүргүүлсэн.	100%
4	Цахим системийн нэвтрүүлэн ашиглалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглалтыг нэмэгдүүлэх.	-	-Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн <a href="https://www.creativehub.mn/">https://www.creativehub.mn/</a> системийн үйл ажиллагааны алдаа, сайжруулах талаар 2 удаа санал өгсөн. Тус системийн сургалтын байгууллагын албан хаагчдад болон соёлын байгууллагын нийт 16 албан хаагчдад 2 удаа сургалт зохион байгуулж 7 уран бүтээлч 1 арга хэмжээг бүртгэсэн. -Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.5 дахь заалтын 98 мэдээллээс өөрт хамаарагдах 46 заалтын мэдээллийг тус газрын <a href="https://da.mos.gov.mn/">https://da.mos.gov.mn/</a> цахим хуудсанд тогтмол нийтэлж байна. Үйл ажиллагааны ил	100%

5	<p>2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах хүрээнд гүйцэтгэлийг нийт албан хаагчид сар бүр тайлагнаж, улирал бүр дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p>	-	<p>тод байдлын хүрээнд 49 цэсэд 1049 мэдээ, мэдээлэл нийтэлсэн.</p> <p>-Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн системд байгууллага, 2 нэгж, 4 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ТЖАХ нарын сар бүрийн буюу 1-12 дугаар сарын тайланг хянаж үнэлэн баталгаажуулалт хийсэн.</p> <p>-Төрийн захиргааны 5 албан хаагчийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах явцын ярилцлагыг төсвийн шууд захирагч, нэгжийн дарга нар 2 удаа хийж, үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.</p> <p>-Нэгжүүдийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах зорилгоор дотооддоо хяналт-шинжилгээ хийж, байгууллагын удирдлагад танилцуулан эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар ярилцаж шийдлийг гаргасан.</p> <p>-"Монгол бичгээр цахимд хэрхэн бичих, Цахим толь, хөрвүүлэх программыг хэрхэн зөв ашиглах", Цахим системийн талаар ойлголт, Цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, Оюуны өмч, зохиогчийн эрх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, "Creativehub" систем, "Энэ жилдээ, эрүүл жиндээ" эрүүл хооллолт, "Эерэг сэтгэцийн эрүүл мэнд зэрэг нийт 6 сургалтад хамрагдсан.</p> <p>-Тус газрын бодлогын мэргэжилтнүүдийг 9 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт хамруулсан. Энэхүү сургалтуудыг ССАЖЗЯ-ны СХОГ, Сангийн яам, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ЦГ-ын ЗЦТ, ОНӨГ, ХГБХХГ, "Архивчны хөгжил" сургалт, арга зүйн төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим шинэчлэл</li> <li>2. Төсвийн хөрөнгө оруулалтын тулгамдаж буй асуудал, туршлага, үр ашгийг сайжруулах</li> <li>3. Соёлын салбарын санхүү, бүртгэлийн албан хаагчдын сургалт, хэлэлцүүлэг</li> <li>4. Залруулгын хүсэлт модулийг бодит орчинд турших сургалт</li> <li>5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай сургалт</li> <li>6. Орон нутгийн өмчит байгууллагуудын нягтлан бодогч, няравуудад зориулсан өмчийн удирдлагатай холбоотой мэдээллийн сургалт</li> <li>7. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийг чадавхжуулах сургалт</li> <li>8. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт</li> <li>9. Хүүхэд хамгааллын бодлого, ойлголтын талаархи сургалт</li> </ol> <p>Эдгээр арга хэмжээнүүд нь мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, холбогдох чиглэлээр мэдлэгийг сайжруулахад чухал ач холбогдол өгсөн.</p>	100%
6	<p>Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтуудад төрийн албан хаагчдыг хамруулах, шаардлагатай тохиолдолд томилолтын асуудлыг шийдвэрлэх.</p>	-	<p>100%</p>	
7	<p>Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн цахим сургалтуудад бүрэн хамруулж мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх.</p>	-	<p>100%</p>	
8	<p>Сургалт хийх тухай бүрт хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулах, шаардлагатай тохиолдолд зардлын асуудлыг шийдвэрлэж өгөх.</p>	1092.6	<p>1. ТА3-ийн 7:4:10 арга зүйн 14 удаагийн цахим сургалтад 11 албан хаагч тогтмол хамрагдаж, Гадаадын тэтгэлэгт хөтөлбөр, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Жендер, Төрийн албан хаагчийн ёс зүй болон шинжлэх ухааны тухай мэдээллийг авсан.</p>	100%

9	Сургалтын ирц, сургалтын материалаар мэдээллийн сан үүсгэж хадгалах.		<p>2. Эерэг сэтгэцийн эрүүл мэнд төслийн хүрээнд "Сэтгэцийн эрүүл мэнд ба чанартай амьдрал" сэдэвт сургалтад 9 албан хаагч хамрагдаж, харилцаа, дасгал хөдөлгөөн, нойр, хоол хүнс, суралцахын ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэл олж авсан.</p> <p>3. Соёлын байгууллагуудын удирдлага, албан хаагчдын манлайлал, ёс зүй, хандлагыг сайжруулах, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллахад анхаарах асуудлаар хууль эрх зүйн тусалцаа үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 120 соёлын салбарын ажилтан, албан хаагчдыг хамарсан сургалтыг зохион байгуулж 8 сэдвийн хүрээнд сургалт, мэдээлэл өгсөн. Уг сургалтыг зохион байгуулахад тус газрын батлагдсан төсөв болох хичээл үйлдвэрлэлийн дадлага зардлын ангилалаас 672,400.00 төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн.</p> <p>4. УБ хотноо зохион байгуулагдсан Салбарын хяналтын улсын байцаагч нарын нэгдсэн зөвлөгөөнд газрын дарга, Улсын ахлах байцаагч, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёлын хяналтын улсын байцаагч нар оролцсон.</p> <p>5. Соёлын байгууллагуудын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2024.12.18-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг бүрэн хангуулан ажиллав.</p> <p>Тус газрын албан хаагчдын сургалтад хамрагдсан судалгааг нарийвчлан гаргуулж, мэдээллийн сан үүсгэсэн.</p> <p>Сургалт зохион байгуулах тухай бүр нь хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж хэвшсэн.</p>	100%
10	Дотооддоо сургалт зохион байгуулах.		<p>1. Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн дотооддоо "Монгол бичгээр цахимд хэрхэн бичих", "Монгол бичгийн цахим толь, хөрвүүлэгч программыг хэрхэн зөв ашиглах" сэдвээр танхимын сургалт зохион байгуулж, монгол бичгийн анхан, дунд шатны цахим хичээлийг хэрхэн үзэж судлах талаар заавар өгөв.</p> <p>2.Зөв зохиистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин албан хаагчдыг эрүүл амьдралын хэв маягт уриалах, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор "Энэ жилдээ эрүүл жиндээ-2" аянд нэгдэж халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдвээр дотооддоо сургалт зохион байгууллаа.</p> <p>3.Зөв зохиистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин албан хаагчдыг эрүүл амьдралын хэв маягт уриалах, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор "Энэ жилдээ эрүүл жиндээ-2" аянд нэгдэж халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдвээр дотооддоо сургалт зохион байгууллаа.</p> <p>4. Тус газрын Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу шинээр томилогдсон 4 албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан.</p> <p>5. "LiveGood" брэндийн эрүүл мэндийн бүтээгдэхүүн болон түүний ашиг тусыг танилцуулах зорилготой сургалтыг дотооддоо амжилттай зохион байгуулсан. Энэхүү сургалт нь байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, бүтээгдэхүүний найрлага, үйлчлэл, хэрэглэх аргачлалын талаар үнэн зөв, мэргэжлийн мэдээлэл авахад чиглэгдсэн болно.</p>	100%

11	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах ажилтны судалгаа гаргаж, саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх, сургалтад хамруулах.	-	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах 3 ажилтны судалгааг гаргаж, саналаа ТА3-ийн Дархан-Уул аймаг дахь СЗ, Соёлын яамны ТЗУГ-т хүргүүлснээс аймгаас 2 квот өгсөн. Үүнд: -Богино хугацааны чиглүүлэх сургалтад Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэнг хамруулсан. -Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэнг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2024.11-р сараас эхлэн хамрагдаж эхэлсэн.	100%
12	Сургалтын техник хэрэгслийг шинэчлэх, нэмэгдүүлэх тал дээр Соёлын яам, аймаг, сумын Засаг дарга, ИТХ-аас дэмжлэг авах, шаардагдах төсвийг батлагдсан төсвийн хүрээнд багтаан шийдвэрлэх.	18.1 сая төгрөг	-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар соёлын салбарт хийгдэж буй 500 сая төгрөгөөс сургалтын техник хэрэгсэл 1 нэр төрлийн 1 ширхэг техник, тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсэгт орж ажилласан. -Улсын төсвөөс соёлын салбарт хийгдсэн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 3 дугаар багцаас тус газарт хуваарилагдсан 14.2 сая төгрөгийн үнэ бүхий Ухаалаг дэлгэц, суурь, удирдах үзэг, видео хурлын төхөөрөмж зэрэг 4 нэр төрлийн 4 ширхэг тоног төхөөрөмжийг 7.4:10 цахим сургалт болон дотооддоо зохион байгуулдаг хурал, сургалтуудад тогтмол ашиглаж байна.	80%
13	Байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, байршуулах, мэдээлэх.	1.0 сая төгрөг	-Орон нутгийн Аа Жи Би телевиз, Ди Би Эс телевиз, Цэцмн зэрэг 3 хэвлэл мэдээллийн байгууллагатай 3.5 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд Ди Би Эс телевизээр 7 мэдээ, Цэцмн сайтаар 12 мэдээ, Аа Жи Би телевизээр 41 мэдээ нийт 60 мэдээ мэдээлэл, контентуудыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан байна. -2024.09.01-ний өдрөөс эхлэн Монгол HD телевизийн Өглөө хөтөлбөрт долоо хоног бүрийн Мягмар гарагт 2 мэдээ бэлтгэн, нийт 26 үйл ажиллагааны талаарх мэдээллийг сурталчилсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд үйл явдлын ач холбогдол, үр дүнг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэхэд анхаарч ажилласан.	100%
14	Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэлийн тайлангийн хамт тайлагнах.	-	Төлөвлөгөөний биелэлтийг эхний болон сүүлийн хагас жилийн байдлаар гаргаж, байгууллагын удирдлагад танилцуулан тайлагнасан.	100%
<b>БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>				



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

ТАНИЛЦСАН:  
ГАЗРЫН ДАРГА

  
С.ТУЯА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ